



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ
АУДИТЫН КОД: БНА-2021/15/-4-ШТА-ГА

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН ДОТООД АУДИТЫН НЭГЖ НЬ ХУУЛИАР
ХҮЛЭЭСЭН **ДОТООД АУДИТ** ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРГИЙГ
БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Аудитор Б.Нарангэрэл
Утас: 99009293 цахим хуудас: narangerelb@audit.gov.mn
Аудитор П.Амаржаргал
Утас: 88106996 цахим хуудас: amarjargalp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ 1. ДОТООД АУДИТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ГЭЖ ТОДОРХОЙЛОГДСОН НЬ ДОТООД АУДИТЫГ БИЕ ДААН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРГИЙГ ОРХИГДУУЛЖ БАЙНА.....	6
1.1.1. Дотоод аудитыг зохицуулсан тусгайлсан хууль байхгүй, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлээр зохицуулагдаж Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж нь санхүүгийн хяналт шалгалтыг түлхүү хийж, дотоод аудит нь стандартын дагуу гүйцэтгэлгүй орхигдох үндэс болж байна.....	6
1.1.2. Санхүүгийн хяналт, аудитын алба нь батлагдсан бүтэц, орон тоонд заасан, шаардлага хангасан дотоод аудиторыг бүрэн ажиллуулалгүй үндсэн орон тоонд гэрээт аудитор авч ажиллаж байгаа нь дотоод аудит хэрэгжүүлэх чиг үүргийн цар хүрээг хязгаарлаж байна.	8
БҮЛЭГ 2. БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯАНЫ ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗААЛТААР НАРИЙВЧЛАН ЗААГЛААГҮЙГЭЭС ДОТООД АУДИТ ХИЙХ ЧИГ ҮҮРГИЙГ ОРХИГДУУЛЖ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ТҮЛХҮҮ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙНА. 13	
2.1.1. Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны дотоод аудитын нэгж нь хуулиар хүлээсэн дотоод аудит гүйцэтгэх чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	13
2.1.2. Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын үйл ажиллагаанд өмнөх онуудад дотоод аудитыг дүрмийн дагуу төлөвлөж, гүйцэтгээгүйгээс шийдвэр гараагүй байна.....	21
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	24
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:	25
ДҮГНЭЛТ: 26	
ЗӨВЛӨМЖ:	27
ҮАГ-ЫН ГУРАВДУГААР ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:	28

Товчилсон үгийн тайлбар

АБ	Ажлын баримт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ДАМПОУС	Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОУМПХ	Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
СХШУАБ	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч
СХШУБ	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны төсөв, орон тооны судалгаа	11
Хүснэгт 2	Санхүүгийн хяналт, аудитын албаны хүний нөөцийн судалгаа	14
Хүснэгт 3	Санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон төлбөрийн акт	18
Хүснэгт 4	Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018-2020 онд хийж гүйцэтгэсэн санхүүгийн хяналт шалгалт	18
Хүснэгт 5	2021 онд хийгдэх дотоод аудитын төлөвлөгөө	19
Хүснэгт 6	Аудитын хорооны хурал, хяналт шалгалтын тоо	21
Хүснэгт 7	2021 онд гүйцэтгэсэн дотоод аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хүний нөөцийн судалгаа	14
Дүрслэл 2	Баянхонгор аймгийн Засаг даргын Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016-2021 оны санхүүгийн хяналт шалгалт ба дотоод аудит хийх хуваарь	15
Дүрслэл 3	Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудит хийх хуваарь /шалгалтын тоо/	16
Дүрслэл 4	Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудит хийхэд зарцуулах хүн өдөр	16
Дүрслэл 5	Баянхонгор аймгийн Засаг даргын Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016-2020 оны санхүүгийн хяналт шалгалт хийсэн төлөвлөгөө, гүйцэтгэл	17
Дүрслэл 6	Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт шалгалтын тоо /2019-2020 он/	17
Дүрслэл 7	Төлбөрийн актын бүтэц	18
Дүрслэл 8	2019-2020 оны төлбөрийн актын биелэлт	18

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоол, МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Аудитын төлөвлөгөө батлах тухай”-ны дагуу Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийв.
Аудитын зорилт	Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв. Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: • Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчтой эсэх. • Төрийн байгууллагууд дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад төрийн байгууллагуудын дотоод аудитын зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, тоон өгөгдөл болон бусад нотлох баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж аудитыг гүйцэтгэв.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, “Төрийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав. Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүрэгтэй холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Б.Нарангэрэл, П.Амаржаргал нар хөтөлбөр, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Аудитын дэд төлөвлөгөөг 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Дарга, Тэргүүлэх аудитораар батлуулж, талбарын ажлыг 2020 оны 09

дугаар сарын 13-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 15-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 10 дугаар сарын 25-аас холбогдох үе шатны хяналтаар хянуулан Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, ҮАГ болон холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

Байхгүй.

БҮЛЭГ 1. ДОТООД АУДИТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ГЭЖ ТОДОРХОЙЛОГДСОН НЬ ДОТООД АУДИТЫГ БИЕ ДААН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРГИЙГ ОРХИГДУУЛЖ БАЙНА.

1.1.1. Дотоод аудитыг зохицуулсан тусгайлсан хууль байхгүй, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлээр зохицуулагдаж Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж нь санхүүгийн хяналт шалгалтыг түлхүү хийж, дотоод аудит нь стандартын дагуу гүйцэтгэлгүй орхигдох үндэс болж байна.

1. Дотоод аудит нь дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандартыг дагаж мөрдөж байгаа бөгөөд дотоод аудитын тухай тусгайлсан дагаж мөрдөх хууль байхгүй бөгөөд "Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1¹-д дотоод аудитын нэгж ажиллуулах хууль эрх зүйн үндсийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосон бөгөөд тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д төсвийн удирдлагын талаарх бүрэн эрхийг нь тусгаж өгсөн байна.

2. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5-д дотоод аудитын дүрмийг Засгийн газар батална гэж заасны дагуу 2015 оны 483 дугаар тогтоолоор "Дотоод аудитын дүрэм"-ийг баталжээ.

3. Сангийн яам нь дотоод аудитыг стандарт арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага JICA-аас хэрэгжүүлсэн "Улсын салбарын дотоод аудитын чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд Дотоод аудиторчуудын институтын "Олон улсын мэргэжлийн Практикийн хүрээ"-ний 2012 оны хувилбарыг Монгол хэлнээ хөрвүүлсэн байна.

4. Төсвийн тухай хуулиар олгогдсон дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах эрхийн хүрээнд Сангийн яамны төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь Дэлхийн банкны олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн хүрээнд "Улсын салбарын дотоод аудитын гарын авлага"-ыг боловсруулсан бөгөөд улмаар 2019 онд Сангийн сайдын тушаалаар "Улсын салбарын дотоод аудитын аргачлал" болон батлагдсан байна.

Аудитын илрүүлэлт

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4-д "Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна" гэж заасан байхад Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 4.7-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудиторт санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, ахлах байцаагчийн эрх олгож болно" гэж заасан нь хуулийн заавал биелүүлэх заалттай зөрчилдөж байна. Тухайлбал: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж нь улсын байцаагчийн эрхгүй албан хаагчийг томилсон бөгөөд энэ талаар аудитын гүйцэтгэх удирдлагаас тодруулахад "Дотоод аудитын дүрэмд Улсын байцаагчийн эрхтэй байж болно гэж заасан тул заавал байцаагч байх шаардлагагүй" гэсэн тайлбар өгсөн.

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

Иймд дээрх журмын заалтыг Төсвийн тухай хуульд нийцүүлж өөрчлөх саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэхийг Үндэсний аудитын газрын аудитын гуравдугаар газарт хүргүүлэв.

5. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасны дагуу 2014 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын албыг байгуулсан бөгөөд 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байгууллагын нэрийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба болгож өөрчилсөн байна.

6. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 09 дүгээр тогтоолоор дараах байдлаар зохион байгуулалт хийсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын бүтцийн нэгжид байгаа “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс”-ийн чиг үүргийг судалж үзэхэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-аар хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Аудитын илрүүлэлт

Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтцэд “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс” байгаа нь ТЕЗ дотоод аудитын 2 нэгжтэй гэж ойлгогдохоор байна.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аймгийн засаг даргын тамгын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолд заасан “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс”-ийн нэршлийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд заасан үндсэн чиг үүрэгтэй нь уялдуулж нэршлийг өөрчлөх саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэхийг Үндэсний аудитын газрын аудитын гуравдугаар газарт хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.4-т “5 жилээс багагүй ажилласан”, Сангийн сайдын 2016 оны 16 тоот тушаалаар баталсан Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагчийн эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журмын 2.2.3-т “Улсын байцаагч нь хяналт шалгалтын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байна” гэж нэг ажлын байранд эсрэг заалт бүхий шаардлага тавьсан байна.

Иймд дээрх дүрэм, журмын зөрчилтэй заалтыг нийцүүлэх саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэхийг Үндэсний аудитын газрын аудитын гуравдугаар газарт хүргүүлэв.

7. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод үйл ажиллагаандаа мөрдөх “Дотоод аудитын дүрэм”-ийг тусгайлан батлаагүй бөгөөд дүрэм батлаагүй шалтгааныг албаны удирдлагаас тодруулахад: “Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-

ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа бөгөөд нэгжийн “Дотоод аудитын дүрэм”-ийн төслийг 2021 оны 1 дүгээр сард боловсруулсан ба аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн боловч Ковид-19 цар тахалтай холбоотой батлуулж амжаагүй байгаа” гэсэн тайлбарыг өгөв.

Аудитын илрүүлэлт

Нэгжийн үйл ажиллагаандаа мөрдөх “Дотоод аудитын дүрэм”-ийн төслийг боловсруулсан ч дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулаагүй байгаа нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 1000²-ыг дагаж мөрдөөгүй байна.

Иймд Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 1000-д заасны дагуу өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлсэн “Дотоод аудитын дүрэм”-ийн төслийг батлуулж ажиллах зөвлөмжийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны удирдлагад хүргүүлэв.

8. Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 1100³-д “Хараат бус байдал ба бодитой хандлага”-ыг тодорхойлжээ.

Аудитын илрүүлэлт

2021 онд Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын захирамжаар “Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулах торгох ял, Зөрчлийн тухай зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт 2019, 2020 онуудад төвлөрүүлсэн мөнгөн дүнд дүн шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах” ажлын хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналтын улсын байцаагчийг оролцуулсан байгаа нь Дотоод аудитын нэгжийг хөндлөнгийн, шууд захирах бус албан тушаалтнаас чиглэл өгч байгаа нь хараат бус байдалд нөлөөлж болзошгүй байна.

Иймд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тохиолдолд зайлшгүй Төсвийн ерөнхийлөн захирагч болон аудитын хороогоор дамжуулан үүрэг чиглэл авч, ДАМПОУС-д заасан хараат бус байдлыг хангаж ажиллахыг Санхүүгийн хяналт, аудитын албаны удирдлагад хүргүүлэв.

1.1.2. Санхүүгийн хяналт, аудитын алба нь батлагдсан бүтэц, орон тоонд заасан, шаардлага хангасан дотоод аудиторыг бүрэн ажиллуулалгүй үндсэн орон тоонд гэрээт аудитор авч ажиллаж байгаа нь дотоод аудит хэрэгжүүлэх чиг үүргийн цар хүрээг хязгаарлаж байна.

9. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь жил бүр аймгийн орон нутгийн төсвөөс бүтэц орон тоо, санхүүжилт батлуулан ажиллаж ирсэн бөгөөд сүүлийн 4 жилийн мэдээллийг доорх хүснэгтээр харуулав.

² Дотоод аудитын нэгжийн зориулалт, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг Дотоод аудитын тодорхойлолт, Ёс зүйн дүрэм, Стандартуудад нийцсэн Дотоод аудитын дүрэмд албан ёсоор тодорхойлох ёстой. Аудитын гүйцэтгэх удирдлага Дотоод аудитын дүрмийг үе үе эргэн хянаж, ахлах удирдлага болон зөвлөлд танилцуулан батлуулж байх ёстой.

³ Дотоод аудитын нэгж хараат бус байх ба дотоод аудиторууд ажлаа гүйцэтгэхдээ бодитой хандах ёстой. **Тайлбар:**Хараат бус байдал гэж дотоод аудитын нэгж дотоод аудитын үүргээ голч байдлаар хэрэгжүүлэх чадавхад заналхийлсэн нөхцөл байдлаас ангид байхыг хэлнэ. Дотоод аудитын нэгж үүрэг хариуцлагаа үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардагдах хараат бус байдлын түвшинд хүрэхийн тулд аудитын гүйцэтгэх удирдлага ахлах удирдлага болон зөвлөлтэй шууд, аливаа хориг саадгүй харилцана. Үүнийг давхар тайлагнах харилцаагаар хэрэгжүүлж болно. Хараат бус байдалд учрах заналхийллийг тухайлсан.

Хүснэгт:1 Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны төсөв, орон тооны судалгаа /Сая төгрөгөөр/

Он	Дотоод аудитын нэгжийн орон тоо		Нийт зардал		Үүнээс:			
					Цалин хөлс		ЭМНДШ	
	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2018	9	9	114.0	114.0	80.8	80.8	9.9	9.9
2019	9	9	145.0	145.0	90.3	90.3	12.3	12.3
2020	9	9	156.9	154.9	114.6	114.6	14.4	14.4
2021	11	11	188.2	183.4	129.1	128.4	17.6	16.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн судалгаа

10. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 01 дүгээр тушаалаар албаны бүтэц орон тоо, цалин хөлсний хэмжээг шинэчлэн баталсан бөгөөд нийт 11 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар баталсан байна. Үүнд:

- Албаны дарга-1,
- Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч-2,
- ахлах аудитор-1 ,
- аудитор-5,
- хүний нөөц, хуулийн зөвлөх, дотоод ажилтан, архив бичиг хэргийн эрхлэгч-1,
- гэрээт-1

Аудитын илрүүлэлт

Тус албаны ажиллагсдын томилогдсон тушаалыг авч албаны даргын баталсан бүтэц орон тоотой тулгаж үзэхэд 3 санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, 1 ахлах аудитор, 4 аудитор байгаа нь Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 01 дүгээр тушаалаар баталсан бүтэц орон тоог баримтлан ажиллаагүй байна.

Иймд батлагдсан орон тоог баримтлан албан тушаалын томилгоог хийж, зөрчлийг арилгах зөвлөмжийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны удирдлагад хүргүүлэв.

11. Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 1210⁴-д зааснаар "... дотоод аудиторууд нь мэргэшсэн дотоод аудиторын эрх болон дотоод аудитын институт болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудаас олгодог бусад эрх мэргэжлийн зохих гэрчилгээ мэргэшлийг авч, чадвараа илтгэн харуулахыг хөхүүлэн дэмжинэ" гэж заасны дагуу Төсвийн тухай хуульд улсын байцаагчийн эрхтэй байна гэж хуулиар тодорхойлж өгчээ. Гэвч Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны аудитораар томилогдсон 4 албан хаагчаас 3 албан хаагч нь улсын байцаагчийн эрхгүй түр орлон гүйцэтгэгч болон гэрээт аудитораар томилогдсон байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4⁵ болон Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ын 4.4-т заасан "...5-аас доошгүй жил ажилласан..." гэсэн шаардлагыг хуулиар тогтоосон байхад ажлын

⁴ Ажлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, бусад чадвар дотоод аудиторуудад дутагдаж байвал аудитын гүйцэтгэх удирдлага чадварлаг зөвлөгөө, тусламж авах ёстой.

⁵ Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна.

байрны зарыг дээрх шаардлагад нийцүүлэлгүй тухайлбал 3-аас доошгүй жил ажилласан байх гэж зааж гэрээт аудиторыг сонгон шалгаруулж авсан байна.

Энэ талаар албаны даргын үүргийн түр орлон гүйцэтгэгчээс тайлбар авахад: “Улсын байцаагчийн эрх авсан шаардлага хангах байцаагч хангалттай бус байдгаас гэрээт аудитор авахаас өөр аргагүй байгаа. Харин энэ жил Төрийн албаны зөвлөлд аудиторын сонгон шалгаруулах ажлын байрны захиалга өгсөн байгаа” гэсэн тайлбар өгөв.

12. Аудитаар ажлын байрны сул орон тоонд захиалга өгсөн эсэх талаар баримт материалаас шалгаж үзэхэд албаны даргын 2019.11.19-ний өдрийн №95 тоот албан бичгээр санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн сул орон тоонд захиалга өгсөн боловч шаардлага хангасан хүний нөөц сонгон шалгаруулалтад ороогүй байна.

Мөн төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн, нөөцөд бүртгэлтэй 3 иргэн байсан бөгөөд ажилласан жилийн шаардлага хангаагүй, төслийн ажилд томилогдсон зэрэг шалтгаанаар 2 иргэн татгалзсан бөгөөд 1 иргэнийг нөөцөөс түр орлон гүйцэтгэгчээр томилсон байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд дотоод аудит хийх шаардлага хангасан хүний нөөцийн хүрэлцээ хангалт муутай бөгөөд санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч болон аудиторууд нь санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудитыг аль алиныг хөрвөн гүйцэтгэж байна.

13. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 онд хийх санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх хуваарийг ТЕЗ-аар батлуулсан бөгөөд уг хуваарийг албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь ажиллах хүчний нөөцөд хуваарилахдаа нийт 250 ажлын өдөр ажиллахаар байхад 173 ажлын өдрөөр хяналт шалгалт, дотоод аудит хийхээр төлөвлөсөн байна.

Энэ талаар аудитын гүйцэтгэх удирдлагаас тодруулахад “Сар бүр 3 өдрийг дотоод ажил, хүний нөөцийг хөгжүүлэх, мэдээ тайлан гаргахад зарцуулах зэргээр төлөвлөсөн” гэх боловч дээрх 3 хоногийг 1 ажилтны ажиллах 11 сараар тооцож үзэхэд 33 өдөр нэмэгдэхээр, амралтын дундаж хоног 20 өдрийг нэмж өгөхөд 226 өдөр байхаар төлөвлөж 24 өдрийг ажил төлөвлөгөөгүй хуваарь гаргасан байна.

Иймд ажиллах хүчний нөөцийг оновчтой хуваарилан төлөвлөж, дотоод аудитын цар хүрээг нэмэгдүүлж, ТЕЗ-чийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудад зөвлөн туслах чиг үүргийн хүртээмжийг нэмэгдүүлж, үр нөлөөтэй ажиллан Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 2030⁶-ыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны удирдлагад хүргүүлэв.

14. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод үйл ажиллагаандаа мөрдөх “Дотоод аудитын дүрэм”-ийг тусгайлан батлаагүй байгаа нь

⁶ Аудитын гүйцэтгэх удирдлага батлагдсан төлөвлөгөөг биелүүлэхэд дотоод аудитын нөөцийг зохистой, хангалттай бөгөөд үр нөлөөтэй хуваарилах ёстой.

аудитын хараат бус байдал алдагдах эрсдэл үүсэж болзошгүй байна. Одоогийн мөрдөж байгаа Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”-ийн 8.3⁷-т хараат бус байдлыг тодорхойлсныг цаашид батлуулж мөрдөх, дотоод аудитын дүрэмдээ тусгахыг аудитын гүйцэтгэх удирдлагад зөвлөв.

15. Санхүүгийн хяналт, аудитын алба нь өмнөх онуудад эрсдэлд суурилсан төлөвлөгөө гаргаж байгаагүй бөгөөд нь 2021 оноос эхлэн Сангийн сайдын 2019 оны 268 тоот тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны нийт 158 байгууллагын эрсдэлийг үнэлж, шалгах асуудлын төлөвлөгөөг гаргасан нь ДАМПОУС-ийн 2010⁸-дахь стандартад нийцсэн бөгөөд хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй хараат бус байдал хангагдах нэгэн үзүүлэлт болсон байна.

16. Тус алба нь 2021 оны байдлаар 11 орон тоотойгоор бүтэц зохион байгуулалт хийгдсэн бөгөөд гүйцэтгэлээр 10 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 0-5 жил ажилласан 1, 5 буюу түүнээс дээш жил ажилласан 9, магистрын зэрэгтэй 7, бакалаврын зэрэгтэй 3 албан хаагч ажиллаж байна.

Дээрх батлагдсан орон тооны ахлах аудитор болон аудитораар ажиллаж буй 6 албан хаагчийн ажлын байранд тавигдах шаардлагыг авч үзэхэд 1 албан хаагч нь 5 - аас доошгүй жил ажилласан байх, 2 албан хаагч нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх гэсэн шаардлагыг хангаагүй нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.4⁹-д заасан заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт №2: Санхүүгийн хяналт, аудитын албаны хүний нөөцийн судалгаа /аудитораар/

дд	Овог нэр	Албан тушаал	Мэргэжил	Мэргэжлийн зэрэг	Улсын байцаагчийн эрхтэй эсэх	мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан
1	Н.Батчимэг	Ахлах аудитор	Геологич, нягтлан бодогч	Бакалавр	тийм	тийм
2	Д.Төмөрхуяг	Аудитор	Нягтлан бодогч, бизнесийн удирдлага	Магистр	тийм	тийм
3	Б.Бат-Эрдэнэ	Аудитор	Нягтлан бодогч, бизнесийн удирдлага	Магистр	тийм	тийм
4	Д.Түвшинтөгс	Аудитор	Санхүүч, мэдээлэл зүй	Магистр	үгүй	тийм

⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч нь дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт болон уг үйл ажиллагааг баримтжуулалтад зайлшгүй хэрэглэх техник, тоног төхөөрөмж, дотоод аудитор чиг үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд бүх талаар дэмжлэг үзүүлж ажиллана.

⁸ Аудитын гүйцэтгэх удирдлага байгууллагын зорилгуудад нийцүүлэн дотоод аудитын нэгжийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох үүднээс эрсдэлд суурилсан төлөвлөгөө гаргах ёстой.;

⁹ Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна.

5	Б.Бат-Эрдэнэ	Аудитор	Нягтлан бодогч	Бакалавр	үгүй	үгүй
6	Л.Оюундэлгэр	Аудитор	Нягтлан бодогч, бизнесийн удирдлага	Магистр	үгүй	тийм

Эх сурвалж: Санхүүгийн хяналт аудитын албанаас ирүүлсэн судалгаа



17. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”-д дотоод аудиторын эрх, үүргийг тодорхойлж өгсөн бөгөөд хяналт шалгалт хийхдээ дээрх үүргийг хэрхэн биелүүлсэн талаар авч үзэхэд журамд заасны дагуу нууцын баталгааг хугацаанд нь гаргасан байна.

18. Мөн Төрийн албаны салбар зөвлөлд ёс зүйн зөрчлийн мэдээг жил бүр хүргүүлэн ажилласан байна.

БҮЛЭГ 2. БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯАНЫ ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗААЛТААР НАРИЙВЧЛАН ЗААГЛААГҮЙГЭЭС ДОТООД АУДИТ ХИЙХ ЧИГ ҮҮРГИЙГ ОРХИГДУУЛЖ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ТҮЛХҮҮ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙНА.

2.1.1. БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДОТООД АУДИТЫН НЭГЖ НЬ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ДОТООД АУДИТ ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРГИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

19. Баянхонгор аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба нь Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-д заасан санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа ч Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-д заасан дотоод аудит хийх чиг үүргээ хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллагаагүй байна.

20. Харин 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг батлуулахдаа эрсдэлд суурилсан гүйцэтгэл, нийцлийн аудит, дотоод аудит, зөвлөн туслах үйл ажиллагааг тусгаж өгсөн нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд урт хугацааны төлөвлөгөөний дагуу



2021 онд санхүүгийн хяналт, дотоод аудит хийх нэгдсэн удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулж, хэрэгжүүлж байна.

21. Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт, шалгалт хийх тоо өмнөх оноос буурсан шалтгааныг тодруулахад “Дотоод аудитын ажлын цар хүрээ их учраас, санхүүгийн хяналт шалгалтыг багасгасан” гэсэн тайлбарыг өгсөн.

Дээрх төлөвлөгөөнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгжийн хийх хяналт шалгалтын бүтцийг тоогоор авч үзвэл 76 хувийг хяналт шалгалт хийхэд, 24 хувийг дотоод аудит хийхээр, хүний нөөцийн ажлын чиг үүргийн ачааллаар нь авч үзвэл 57 хувийг санхүүгийн хяналт шалгалт, 43 хувийг дотоод аудит хийхэд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Дүрслэл 3: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ БОЛОН ДОТООД АУДИТ ХИЙХ ХУВААРЬ /ШАЛГАЛТЫН ТОО/



Дүрслэл 4: Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудит хийхэд зарцуулах хүн өдрийг харьцуулбал



22. Аудитаар 2021 онд гүйцэтгэсэн сумдын сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн санд хийгдсэн дотоод аудитын ажлын баримт материалыг түүвэрлэн “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-д нийцүүлж Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу гүйцэтгэсэн эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт

1. Ажлын баримт 1000-Аудитын ажлын удирдамж дээр аудитын хамрах хүрээний хязгаарлалт, дотоод аудитын дүнг тайлагнах хэсгийг тусгаагүй, нийтлэг үндэслэл хэсэгт байгууллагын батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа эсэх, болон аудитын төрлийг тодорхой тусгаж өгөөгүй, удирдамж дээрх баталгаажуулах хэсгийг стандартын дагуу хийгээгүй, ажлын удирдамжийг батлахдаа Засаг даргаар батлуулаагүй, мөн аудитын удирдамж дээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа хянан удирдаж байгаа болон гүйцэтгэж байгаа албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бичээгүй;
2. Ажлын баримт 2000-Дотоод аудитын ажлын төлөвлөгөө, Ажлын баримт -2001-дотоод аудитад шаардлагатай материалын жагсаалтад хянасан ажилтны нэр албан тушаалыг оруулаагүй.
3. Илэрсэн асуудлын нэгтгэлийг Ажлын баримт -3000 маягтын дагуу бэлтгээгүй,
4. Ажлын баримт -4000-Дотоод аудитын ажлын тайланг аргачлал, ажлын баримтын дагуу бэлтгээгүй,
5. Байгууллагын эрсдэлийн удирдлагын талаар нарийвчилсан асуулга / Ажлын баримт -1003/ мөн байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар нарийвчилсан асуулга /АБ1004/ ажлын баримтыг тус тус бүрдүүлээгүй атлаа аудитын дүгнэлтэд 2 дугаар түвшинд буюу “**сайжруулах шаардлагатай**” гэж дүгнэсэн байна.
6. Аудитыг гүйцэтгэх үеийн эрсдэл хяналтын матриц / Ажлын баримт -2003/-ыг хийгээгүй байгаа нь тухайн аудитын гүйцэтгэх шатны эрсдэлийг тодорхойлж үнэлээгүй, уг эрсдэлд чиглэсэн хяналт байхгүй, эрсдэлд чиглэсэн дотоод хяналтын талаарх мэдээлэл зэргийг үнэлэхгүйгээр аудитын дүгнэлтийг үндэслэлгүйгээр өгсөн гэж үзэхээр байна.

Иймд дотоод аудитыг гүйцэтгэхдээ “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-д нийцүүлж Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу эрсдэлийн

удирдлага, хяналт, засаглалын аливаа үйл ажиллагааны үр өгөөжийг дотоод аудитын мэргэжлийн үүднээс системтэйгээр үнэлж, дүгнэлт өгч ажиллах зөвлөмжийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны удирдлагад хүргүүлэв.


23. Тус алба нь 2016-2020 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг аймгийн Засаг дарга буюу аудитын хорооны даргаар батлуулсан бөгөөд уг төлөвлөгөөнд зөвхөн төсөвт байгууллагуудад болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид **санхүүгийн хяналт шалгалт** хийхээр тусгасан атлаа **дотоод аудитыг хэрэгжүүлэх** талаар тусгаагүй улмаас дотоод аудит хийгдээгүй Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

24. Тус албаны 2016-2020 онд төлөвлөсөн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байдлыг шалгахад 2018 онд 2, 2019 онд 9, 2020 онд 2 байгууллагыг шалгаагүй нь Сангийн яамнаас шалгалтыг хойшлуулсан мөн шалгагч ажлаас чөлөөлөгдсөн, “Баянхонгор хайрхан фарм” ХХК-ны үйл ажиллагааг шалгах цар хүрээ ихтэй төлөвлөгөөт бус хяналт шалгалт гүйцэтгэсэн зэрэг шалтгаан тайлбарыг ирүүлсэн байна.

Дүрслэл: 5 Баянхонгор аймгийн Засаг даргын Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016-2020 оны санхүүгийн хяналт шалгалт хийсэн төлөвлөгөө, гүйцэтгэл



Дүрслэл 6: Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт шалгалтын тоо /2019-2020 он/




Харин санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүд дараах байдалтай байна. Үүнд:

2019 онд төлөвлөгөөт шалгалтаар 100 байгууллагад хяналт шалгалт хийхээс 97, төлөвлөгөөт бус 4, нийт 101 байгууллагад хяналт шалгалт хийжээ. 2020 онд төлөвлөгөөт 87, төлөвлөгөөт бус 4 нийт 91 санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна.

Хүснэгт 3: Санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон төлбөрийн акт /сая төгрөг/

Он	тоо хэмжээ	Төлбөрийн акт			Нийт	Актын биелэлт
		Орон нутгийн төсөвт	Тухайн байгууллагад	Хуулийн байгууллагад шилжүүлсэн		
2018 он	110	58.3	89.6	19.8	167.7	69.0%
2019 он	134	88.9	101.6	63.8	254.3	83.3%
2020 он	132	63.7	537.0		600.7	68.7%

Эх сурвалж: СХАА-аас ирүүлсэн зөрчлийн нэгтгэл



25. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018-2020 онд хийж гүйцэтгэсэн санхүүгийн хяналт шалгалтын тайланг түүврийн аргаар хугацаандаа гүйцэтгэсэн эсэхийг тулгалаа.

Хүснэгт №4: Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018-2020 онд хийж гүйцэтгэсэн санхүүгийн хяналт шалгалт /түүврээр/

дд	Огноо	Байгууллагын нэр	Удирдамжид заасан хугацаа		Гүйцэтгэлээр хугацаа		Хугацаа хэтрэлт	
			Эхлэх	Дуусах	Эхлэх	Дуусах	Эхлэх	Дуусах
1	2018 он	Орон нутгийн өмчийн газар	11/28/2018	12/7/2018	11/28/2018	12/7/2018	1	1
2		Номын сан	3/13/2018	3/26/2018	3/13/2018	3/29/2018	1	4
3		Нэгдсэн эмнэлэг	5/23/2018	6/20/2018	5/23/2018	8/6/2018	1	34
4	2019 он	5-р цэцэрлэг	3/13/2019	3/22/2019	3/21/2019	3/29/2019	7	6
5		13-р цэцэрлэг	11/7/2018	11/28/2018	4/1/2019	4/9/2019	104	95
6		11-р цэцэрлэг	4/29/2019	5/7/2019	4/29/2019	5/7/2019	1	1
7	2020 он	“Чандмань-Баянхонгор” ХК	1/27/2020	2/14/2020	1/28/2020	2/14/2020	2	1
8		Хөгжимт драмын театр	3/11/2020	3/24/2020	3/2/2020	4/3/2020	-8	9
9		Баянговь сумын ЗДТГ	11/4/2020	11/13/2020	11/4/2020	11/11/2020	1	-3

Эх сурвалж: СХАА-аас ирүүлсэн 2018-2020 оны тайлан

Аудитын илрүүлэлт

1.Санхүүгийн хяналт, аудитын алба нь нийт удирдамжид заасан хяналт шалгалтыг 1-104 хоногоор хоцроож байгаа Сангийн сайдын 2016 оны 107 дугаар

тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт, шалгалтын стандарт”-ын 3.1.3¹⁰-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. 2021 онд төлөвлөгдсөн 6 аудитаас 3 дугаар улирлын байдлаар 5 аудитыг бүрэн гүйцэтгэхээр төлөвлөсөн байхад 2 аудитыг 2021.05.26-ны өдөр дуусахаар хугацааг төлөвлөсөн ч 2021.06.30-ны өдөр тайлагнаснаас харахад төлөвлөсөн ажлыг хугацаандаа гүйцэтгэхгүй аудитын ач холбогдлыг бууруулж байна.

Иймд хяналт шалгалтыг төлөвлөсөн хугацааг баримтлан гүйцэтгэж, аудитын ач холбогдлыг алдагдуулахгүй ажиллах зөвлөмжийг Санхүүгийн хяналт, аудитын албаны удирдлагад хүргүүлэв.

26. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь стратеги төлөвлөгөөнд дотоод аудит хийх хуваарийг батлахдаа дотоод аудит хийх чиг үүргээ орхигдуулж баталсан байна.

Гэвч 2021-2024 оны стратеги төлөвлөгөө батлахдаа дээрх зөрчлийг арилгаж, дотоод аудит хийх чиг үүргийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан байна.

Хүснэгт 5: 2021 онд хийгдэх дотоод аудитын төлөвлөгөө

№	Дотоод аудит хийх сэдэв	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлтийн Хувь	Тайлбар
1	Орон нутгийн төсвийн төсвийн орлого бүрдүүлэлт , ангилагдаагүй зардал, замын сан	2021.03.01-2021.04.23	70%	Сангийн яамнаас Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэст санхүүгийн хяналт шалгалт хийх захиалга өгсөнтэй холбоотойгоор орон нутгийн төсвийн орлогод хийх дотоод аудитын хугацааг түр хойшлуулсан байна.
2	Сумдын ОНХС	2021.05.06-2021.05.26	100%	
3	Сумдын Сум хөгжүүлэх сан	2021.05.06-2021.05.26	100%	
4	Аймгийн төсөвт байгууллагуудын дотоод хяналт	2021.05.28-2021.06.17	60%	Сангийн яамнаас Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэст санхүүгийн хяналт шалгалт хийх захиалга өгсөнтэй холбоотойгоор аудитын хугацааг хойшлуулсан.
5	Боловсролын байгууллагуудын цалин хөлс	2021.07.08-2021.08.10	75%	Төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар ээлжийн амралт болон Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хугацаа түр хойшлуулсан.
6	Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай дүгнэлт авсан, дүгнэлт өгөхөөс татгалзсан байгууллагуудад дотоод аудит хийх	2021.10.28-2021.11.11	-	Хугацаа болоогүй

¹⁰ Хяналт шалгалт явуулах хугацааг тогтоосон байна. Энэ хугацааг тогтоохдоо шалгалтын тайлан гаргах хугацааг тооцно”

Эх сурвалж: СХАА-ны 2021 оны батлагдсан төлөвлөгөө

27. 2021 онд хийгдэх дотоод аудитын төлөвлөгөөнөөс харахад сумдын ОНХС, сумдын Сум хөгжүүлэх санд хийсэн дотоод аудит бүрэн дууссан бөгөөд аудитын хорооны хурлаар дүнг хэлэлцээгүй байна. Энэ талаар тодруулахад Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хорооны гишүүд хуралдах боломжгүй болсон байна.

28. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалт, аудитын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах зарчмыг “Дотоод аудитын дүрэм”-ийн 3.1¹¹-д тодорхойлсон байна.

29. Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 оны 3 дугаар улирлын байдлаар гүйцэтгэхээр төлөвлөсөн аудитын 40 хувийг хугацаанд нь гүйцэтгэж, 60 хувийг нь хугацаа хоцроож гүйцэтгэсэн нь Сангийн яамнаас 2 төсвийн байгууллагад хяналт шалгалт хийх чиглэл өгсөн, ИТХ-ын даргын захирамжаар “Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулах торгох ял, Зөрчлийн тухай зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт 2019, 2020 онуудад төвлөрүүлсэн мөнгөн дүнд дүн шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах” ажлын хэсэгт 1, аймгийн Засаг даргын захирамжаар 3 байгууллагад хяналт шалгалт хийх ажлын хэсэгт ажиллах хүчний нөөцийг хуваарилсан мөн Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас аудитыг хугацаанд нь гүйцэтгээгүй байна.

30. Аудитаар дотоод аудитын 2021 оны ажлын баримтын материалыг түүвэрлэн үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- Аудитын удирдамж дээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа хянан удирдаж байгаа болон гүйцэтгэж байгаа албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бичээгүй байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹² дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- Дотоод аудитын нэгжийн удирдлага нь нэгжийн зохион байгуулалт, үйл ажиллагааны хараат бус байдлыг гүйцэтгэх удирдлага жил тутам зөвлөлд

¹¹ Дотоод аудитын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалт, аудитын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтална

¹² Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

тайлагнаагүй байгаа нь дотоод аудитын “Мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-ний 1100¹³, 1110¹⁴-д заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд дотоод аудитыг гүйцэтгэх болон хянан удирдах албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилгүйн мэдэгдлийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу илэрхийлж, гүйцэтгэх удирдлага аудитын хороонд зохион байгуулалтын хараат бус байдлыг стандартад заасны дагуу тайлагнаж ажиллах зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

31. Өмнөх онуудад хийгдсэн санхүүгийн хяналт шалгалтын дүнг аудитын хорооны хурлаар хэлэлцсэн байдлыг он тус бүрээр авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 6: Аудитын хорооны хурал, хяналт шалгалтын тоо

Он	Хорооны хурал хуралдсан тоо	Хяналт шалгалтын тоо	Хорооны хурлаар тайланг авч хэлэлцсэн байгууллагын тоо	Хувь
2016	14	122	76	62.3%
2017	8	144	68	47.2%
2018	8	75	66	88.0%
2019	3	121	3	2.5%
2020	3	87	13	14.9%

Эх сурвалж: Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн судалгаа

Дээрх хүснэгтээс харахад гүйцэтгэсэн хяналт шалгалт бүрийг аудитын хорооны хурлаар хэлэлцүүлээгүй байгаа шалтгааныг ахлах аудитораас тодруулахад “Аудит бүрийг хорооны хурлаар оруулж хэлэлцүүлдэггүй, зөрчлийн хэмжээнээс хамаарч аль байгууллагыг оруулахыг шийдвэрлэж цаашид авах арга хэмжээний талаар аудитын хорооноос шийдвэрийг гаргуулдаг” гэсэн тайлбарыг өглөө.

Цаашид санхүүгийн хяналт шалгалтын дүнг улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хийж, зөвхөн дотоод аудитын дүнг хорооны хурлаар хэлэлцүүлэн тухай бүр нь баталгаажуулж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөв.

32. Харин 2021 онд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудит болон хяналт шалгалт хийх төлөвлөгөөнд дотоод аудитын хорооны хурлыг 3 удаа хийхээр төлөвлөсөн бөгөөд аудитын хорооны хурал хугацаандаа

¹³ Дотоод аудитын нэгж хараат бус байх ба дотоод аудиторууд ажлаа гүйцэтгэхдээ бодитой хандах ёстой.

¹⁴ Дотоод аудитын нэгжид үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх боломж олгож буй байгууллагын доторх тухайн түвшинд аудитын гүйцэтгэх удирдлага дотоод аудитын нэгжийн зохион байгуулалтын хараат бус байдлыг зөвлөлд наад зах нь жил тутам нотолж байх ёстой.

хуралдаагүй байгаа нь аудитын ач холбогдлыг бууруулах, хараат байдалд оруулах нөхцөл байдал үүсэж байна.

Иймд Сангийн сайдын 2019 оны 29 тоот тушаалаар баталсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.2¹⁵-д заасны дагуу дотоод аудитын дүрмийн хорооны хурлыг аудитын дүнг хэлэлцэх тухай бүрд нь хуралдуулж, аудитын чиг үүрэг хэрэгжүүлж буй дотоод аудитын нэгжийг хараат бусаар хязгаарлалтгүй ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж, аудитын ач холбогдолтой байдал, үр нөлөөг гаргаж ажиллахыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

33. Дотоод аудитын үр дүнг олон нийтэд ил тод мэдээлээгүй, мэдээллийн санг бүрдүүлээгүй бөгөөд олон нийтэд мэдээлэх талаар стандарт болон хууль эрхзүйн заалт байхгүй бөгөөд дотоод аудитын эцсийн зорилго нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд алдаа, зөрчлийг багасгах, эрсдэлийг бууруулах, удирдах явдал тул олон нийтэд заавал мэдээлэх шаардлагагүй юм.

34. Харин Баянхонгор аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба нь эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилж байгаа нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1¹⁶, 7.1.4¹⁷-д заасан үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж байна.

35. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол “Дотоод аудитын дүрэм” -ийн 7.9¹⁸-д заасны дагуу Сангийн яамны санхүүгийн эрсдэлийн удирдлагын газарт хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлангаа хүргүүлж ажилласан байна.

36. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албаны үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана” гэж заасны дагуу Сангийн яамнаас 2018 онд Санхүүгийн хяналт, аудитын

¹⁵ Дотоод аудитын нэгжийн гүйцэтгэсэн аудитын үр дүнг хэлэлцэх, шийдвэр гаргах, зөвлөгөө өгөх

¹⁶ эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх.

¹⁷ үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;

¹⁸ Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх санхүүгийн хяналт шалгалт, аудитын нэгж нь хагас, бүтэн жилийн тайлангаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг хариуцсан газарт жил бүрийн 7 дугаар сарын 10-ны өдөр болон тухайн жилийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ..

албаны ажилтнуудад зориулсан дотоод аудитын сургалт, 2019 онд санхүүгийн хяналт, аудитын ажилтны нэгдсэн зөвлөгөөн, 2020 онд дотоод аудитын аргачлал, чанарын үнэлгээний аргачлал, олон улсын сайн туршлагауд болон дотоод аудит, хяналт шалгалтыг гүйцэтгэхэд анхаарах асуудлын талаар улсын салбарын дотоод аудиторуд, санхүүгийн хяналтын улсын байцаагч нарыг хамруулсан “Улсын салбарын дотоод аудиторудын зөвлөгөөн”-ийг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 13 хүн сургалтад хамрагдсан байна.

2.1.2.Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын үйл ажиллагаанд өмнөх онуудад дотоод аудитыг дүрмийн дагуу төлөвлөж, гүйцэтгээгүйгээс шийдвэр гараагүй байна.

37. Сангийн яамны эрсдэлийн удирдлагын газар нь чанарын хяналтын үнэлгээг 2 жил тутамд хийлгэхээр Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” -ийн 8.5¹⁹ -д заасан байна.

Аудитын илрүүлэлт

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт аудитын албанд 2014 оноос хойш чанарын үнэлгээг хийлгээгүй байна.

Иймд чанарын хяналтын үнэлгээг 2 жил тутам хийж байх үүргээ биелүүлж ажиллах зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлэх саналыг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газарт хүргүүлэв.

38. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь өмнөх онуудад дотоод аудит хийгээгүй байна.

2021 онд батлагдсан удирдамжийн дагуу сумдын орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх санд дотоод аудит хийсэн бөгөөд аудитаар нийт 413677.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 4359.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 15443.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 48 заалт бүхий 393874.4 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна. Акт, албан шаардлагын зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Хүснэгт 7: 2021 онд гүйцэтгэсэн дотоод аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /мян.төг/

Аудитын нэр	Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сум хөгжүүлэх сан	3	4,359.9	1	15,443.5			4	19,803.4
Орон нутгийн хөгжлийн сан	0	0	0	0	48	393,874.4	48	393,874.4

¹⁹ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ.

Дүн	3	4,359.9	1	15,443.5	48	393,874.4	52	413,677.8
-----	---	---------	---	----------	----	-----------	----	-----------

Эх сурвалж: Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн зөрчлийн нэгтгэл

39. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1²⁰-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийж, төсвийн сахилга батыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэж, үйл ажиллагаагаа явуулсан байна.

40. Харин өмнөх жилүүдэд дотоод аудит гүйцэтгээгүй бөгөөд 2021 оноос Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3²¹-д заасан чиг үүргийн дагуу санхүүгийн хяналт, дотоод аудит хийх нэгдсэн удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан сумдын Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалт, зарцуулалтад дотоод аудит хийж, эрсдэлийг тодорхойлж, үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэж аудит хийж эхэлж байна.

41. Дотоод аудитыг хэрэгжүүлж эхэлснээр төсвийн ашиг сайжрах, үргүй зардлыг багасгаж, төсвийн орлого бүрдүүлэлтийг сайжруулах ач холбогдолтой байна. Тухайлбал: Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтэд дотоод аудит хийснээр төсвийн орлогын төлөвлөгөө бүрэн биелэх, сумдын орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх санд дотоод аудит хийснээр хөрөнгийн үр ашиг сайжрах, боловсролын байгууллагуудын цалин хөлсөнд аудит хийснээр хууль, дүрэм журмын хэрэгжилт үнэн бодитой байх зэрэг ач холбогдолтой байна.

42. Санхүүгийн хяналт, аудитын алба нь Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд 8 дугаар зүйлийн 8.2²²-д заасан хяналтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын шилэн дансны цахим хуудаст мэдээлсэн байдлыг улирал бүрээр хянадаг.

43. Тус алба нь 2018, 2019 онуудад сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалт, зарцуулалтад санхүүгийн хяналт шалгалт хийсэн нь Сангийн сайдын 2014 оны 43

²⁰ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

²¹ Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

²² Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ

дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжийн сангийн заавар”-ын 9.2²³-д заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитаар илэрсэн зөрчилд хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнг сайжруулах, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах 7 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

-oOo-

²³ ОНХС-аас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжилт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоодын аудитын нэгж хэрэгжүүлнэ.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 1/105 тоот албан бичгээр дараах 3 саналыг ирүүлсэн байна.



Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газарт

2021.10.25 № 4/105
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Төрийн аудитын газраас ирүүлсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дүгнэлт хэсгийн 2-т тусгагдсан ОУМПХ-1000-д үйл ажиллагаандаа мөрдөх "Дотоод аудитын дүрэм"-ийг батлуулаагүй гэсэнд 2021 оны 01 дүгээр сард хийгдсэн төсөл, дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний 13-т тусгагдсан байгааг харгалзан үзэж бодит байдлыг тусгуулах, дүгнэлт хэсгийн 5-т 2021 оны батлагдсан төлөвлөгөөнд 24 хувийг дотоод аудит хийхэд чиглэгдсэн байгаа нь хангалтгүй гэсэн заалтыг дотоод аудит, хяналт шалгалт хоёрын тооны харьцуулалтыг ажлын ачаалал гүйцэтгэх хугацаа буюу хүн/өдрөөр тооцуулан тусгуулах, дүгнэлт хэсгийн 8-т Санхүүгийн хяналт, аудитын алба нь ажлын байрны сул орон тоонд шаардлага хангасан дотоод аудитор авч ажиллуулаагүй гэсэн хэсгийн хүрээнд нийт 12 үзүүлэлтийн 100 хувь гэж тооцон 33 хувийг шаардлага хангаагүй байгаагаар тусгуулах саналуудыг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДАВААЖАРГАЛ

E:/Toot A4-2021.docx/

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

№	Санал	Саналд өгсөн тайлбар
1	САНАЛ-1	Тус саналыг хүлээн авч тайланд нэгжийн үйл ажиллагаандаа мөрдөх “Дотоод аудитын дүрэм”-ийн төслийг боловсруулсан ч дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулаагүй гэсэн тайлбарыг нэмэлтээр оруулсан.
2	САНАЛ-2	Тус саналыг хүлээн авч Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгжийн хийх хяналт шалгалтын бүтцийг тоогоор авч үзвэл 76 хувийг хяналт шалгалт хийхэд, 24 хувийг дотоод аудит хийхээр, хүний нөөцийн ажлын чиг үүргийн ачааллаар нь авч үзвэл 57 хувийг санхүүгийн хяналт шалгалт, 43 хувийг дотоод аудит хийхэд зарцуулахаар төлөвлөсөн хэсгийг аудитын тайланд дүрслэл хэлбэрээр оруулсан болно.
3	САНАЛ-3	Тус байгууллагын ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй бөгөөд тайлангийн хэсэгт нэмэлтээр тайлбар оруулсан.

-оОо-

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Дотоод аудитын үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтаар зохицуулсан бөгөөд дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд мөрдөх стандартыг “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-аар зохицуулж байна.
2. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Олон Улсын Мэргэжлийн Практикийн хүрээ 1000-д заасан “Дотоод аудитын дүрэм”-ийг батлуулаагүй байна.
3. Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтцэд “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс” гэж байгаа нь нэршлийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч нь дотоод аудитын 2 нэгжтэй гэж ойлгогдохоор байна.
4. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.4, Сангийн сайдын 2016 оны 16 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагчийн эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ын 2.2.3 дахь заалтуудын зөрчилдөөнөөс шалтгаалж шаардлага хангасан хүний нөөц бүрдэхгүй байна.
5. Дотоод аудитын хорооны хурал төлөвлөсөн хугацаандаа хуралдахгүй байгаа нь гүйцэтгэсэн аудитын ач холбогдлыг бууруулж байна.
6. ТЭЗ-аас өөр албан тушаалтан аудиторыг цаг үеийн шинжтэй ажлын хэсэгт оруулан томилж байгаа нь “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-д заасан хараат бус байдал алдагдах нөхцөл байдал үүсгэж байна.
7. Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 оны 3 дугаар улирлын байдлаар дотоод аудитыг гүйцэтгэхдээ “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-ыг иж бүрэн мөрдөөгүй, хугацааг баримтлаагүй байна.
8. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагаанд чанарын хяналтын үнэлгээ байгуулагдсан цагаас хойш хийгээгүй байна.

-оОо-

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ: БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Дотоод аудитын хорооны хурлыг аудитын дүнг хэлэлцэх тухай бүрд нь хуралдуулж, аудитын ач холбогдолтой байдал, үр нөлөөг гаргаж Сангийн сайдын 2019 оны 29 тоот тушаалаар баталсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.2-д заасан хэрэгжүүлж ажиллах.
2. Дотоод аудитын нэгжид хөндлөнгийн, шууд захирах бус албан тушаалтнаас үүрэг чиглэл өгдөг явдлыг зогсоож, хараат бусаар ажиллах нөхцөл бололцоог хангаж, дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 1100-г мөрдөж ажиллах.

ХОЁР: БАЯНХОНГОР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДАВААЖАРГАЛ ТАНАА:

1. Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт 1000-д заасны дагуу өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн дотоод аудитын дүрмийг боловсруулан батлуулж ажиллах.
2. Батлагдсан бүтэц, орон тоог Төрийн албаны тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, ажиллах хүчний нөөцийг оновчтой хуваарилан төлөвлөж ажиллах.
3. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 -д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, дотоод аудитыг гүйцэтгэхдээ “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”, Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ыг мөрдөж ажиллах.
4. Төсвийн ерөнхийлөн захирагчаас баталж өгсөн дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалтыг хийхдээ төлөвлөсөн хугацааг хэтрүүлдэг байдлыг таслан зогсоож, төлөвлөсөн арга хэмжээг гүйцэтгэж байх.
5. Дотоод аудитыг гүйцэтгэх болон хянан удирдах албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилгүйн мэдэгдлийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу илэрхийлж, гүйцэтгэх удирдлага аудитын хороонд зохион байгуулалтын хараат бус байдлыг стандартад заасны дагуу тайлагнаж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 07 дугаар сарын 05-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

-oOo-

ҮАГ-ЫН ГУРАВДУГААР ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аймгийн засаг даргын тамгын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолд заасан “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс”-ийн нэршлийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд заасан үндсэн чиг үүрэгтэй нь уялдуулж нэршлийг өөрчлөх саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
2. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.4-т “...**5 жилээс багагүй ажилласан**”, Сангийн сайдын 2016 оны 16 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагчийн эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ын 2.2.3-т “**Улсын байцаагч нь хяналт шалгалтын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байна**” гэж нэг ажлын байранд эсрэг утгатай заалт бүхий шаардлага тавьсан байгаа тул дүрэм, журмын зөрчилтэй заалтыг нийцүүлэх саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
3. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.7-д “**Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитор санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, ахлах байцаагчийн эрх олгож болно**” гэсэн заалт нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4-д “**Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна**” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул уг заалтыг Төсвийн тухай хуульд нийцүүлж өөрчлөх саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
4. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” -ийн 8.5-д заасны дагуу “Чанарын хяналтын үнэлгээ”-г 2 жил тутам хийх үүргээ биелүүлж ажиллах зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлэхээр уламжилж байна.

-оОо-